

ТҮР ХАМГААЛАН БАЙРЛУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ, НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ, ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ, СЭТГЭЛ ЗҮЙН
ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ, ХОЛБОН ЗУУЧЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ
АЖИЛТНЫГ ДАВТАН СУРГАХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго ньГэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх түр хамгаалан байрлуулах үйлчилгээ, нийгмийн халамжийн үйлчилгээ, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажилтныг давтан сургах сургалтыг зохион байгуулах харилцааг зохицуулна.

1.2.Сургалтыг зохион байгуулах, салбарын холбогдох ажилтнуудыг хамруулах үйл ажиллагаа нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай, Нийгмийн халамжийн тухайхууль болон тэдгээртэй нийцэж гарсан эрх зүйн акт, бусад хууль тогтоомжоор зохицуулагдана.

1.3.Хуулийн хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлэх,мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий ажилтнуудыг давтан сургах сургалтыг хамтран зохион байгуулах Засгийн газрын болон орон нутгийн хэрэгжүүлэгч агентлагуудын ажлын уялдаа холбоо, нийгэм сэтгэл зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх тогтолцоог сайжруулах, шинэ механизмуудыг бий болгож хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг мэргэшүүлэн бэлтгэнэ.

1.4.Түр хамгаалан байрлуулах, нийгмийн халамжийн, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах нь хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, туслалцаа дэмжлэг үзүүлэх мэргэжлийн цогц үйл ажиллагаа юм.

1.5Давтан сургах сургалтын зорилго нь хувь хүний хөгжил, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх болонажлын байрны тодорхойлолтод заасан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүргийгхэрэгжүүлэхэддэмжлэг үзүүлэхэд оршино. Ажлын байран дахь сургалтын зорилго нь асуудал хариуцсан ажилтнууд ур чадвараа хөгжүүлэх, харилцан суралцах замаар үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа хөгжихөд чиглэнэ.

Хоёр.Хамрах хүрээ

2.1.Нийгмийн хамгааллын салбарын түр хамгаалан байрлуулах, нэг цэгийн, хүүхэд хамгаалал, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, холбон зуучлах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдлага, ажилтнууд жил бүр давтан сургах сургалтанд хамрагдана.

Гурав.Давтан сургах сургалтад тавигдах шаардлага

3.1. Давтан сургах сургалт нь дараах шаардлагыг хангасан байна.

3.1.1.Сургалтын зорилго нь зорилтот бүлгийн хөгжих, суралцах хэрэгцээшаардлагад үндэслэсэн байх

3.1.2. Сургалтын агуулга нь зорилтот бүлгийн ажил мэргэжлийн онцлог,ажлын байрны чиг үүрэгт нийцсэн байх

3.1.3. Сургалтын арга зүй нь зорилтот бүлгийн сонирхол хүсэл дээр суурилан сонголт хийх, гүнзгийрүүлэн судлах, туршлага, судалгааны үр дүнг хуваалцах,мэдээлэл, технологид суурилсан байх

3.1.4.Сургалтын зохион байгуулалт нь байршил, цаг хугацаа, давтамжийн хувьд оновчтой байх

3.1.5.Сургалтын үнэлгээ нь суралцсан агуулга, хөтөлбөрийн хэрэгжилтийн үрдүнгээрүнэлэгдэх

3.1.6.Сургалт нь сэдэвчилсэн сургалт, цахим сургалт, зайны сургалт зэрэголонхэлбэртэй байж болно.

3.1.7. Сургалтанд хэрэглэгдэх гарын авлагатай байна.

Дөрөв. Давтан сургах сургалтын зохион байгуулалт

4.1. Сургагч багш нарыг бэлтгэх үндсэн сургалтыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрынСургалт, мэдээллийн нэгжүүдийн Хамтарсан сургалтын баг зохион байгуулна. Хамтарсан сургалтын багт магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагын болон ОУБ-ын төлөөлөл орж болно. Сургалтын багийн гишүүн бакалавраас дээш зэрэгтэй,

салбартаа мэргэжлээрээ 5-оос доошгүй жил ажилласан туршлагатай байх шаардлагыг хангасан байна.

4.2. Давтан сургах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг Хамтарсан сургалтын баг боловсруулна.

4.3. Ажлын байран дахь сургалтын агуулга, хөтөлбөр, төлөвлөгөөг тухайн байгууллагын сургалтын нэгж боловсруулж, баталгаажуулна. Ажлын байран дахь сургалт нь байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдсан байх ба гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх асуудал хариуцсан нэгж мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллана.

4.4. Давтан сургах сургалт зохион байгуулах чиг үүрэгтэй сургалт, арга зүйн төвүүд сургалтанд хамрагдсан багш, ажилтны талаарх мэдээллийн сантай байна.

4.5. Үндэсний хэмжээний үндсэн сургалтын үргэлжлэх хугацаа 3-5 хоног, орон нутгийн үндсэн сургалтын үргэлжлэх хугацаа 3 хоног байна.

4.6. Үндсэн болон төрөлжсөн сургалтад хамрагдаж, хөтөлбөрийн агуулгыг дүүргэсэн мэргэжилтэн, удирдах ажилтанд улсын нэгдсэн бүртгэлтэй батламж, гэрчилгээ олгоно.

4.7. Батлагдсан загварын дагуу батламж хэвлүүлж олгох ажлыг тухайн сургалтыг явуулсан байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

Тав. Давтан сургах сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага

5.1. Сургалтын хөтөлбөрт Монгол улсын хууль, тогтоомж болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийн хэрэгжилтийн байдалд хяналт тавих, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргээх, соён гэгээрүүлэх, таслан зогсоох болон хохирогчдыг хамгаалах үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн эрх, хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ болон ажилтнуудын өөрийгөө хамгаалах чадвар, аюулгүй байдал, стресс менежмент, хандлага өөрчлөх талаарх агуулга тусгагдсан байна.

5.2. Давтан сургах бүх төрлийн сургалтын хөтөлбөрт дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд:

5.2.1. Сургалтын хөтөлбөр нь энэхүү журмын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх

5.2.2.Тухайн сургалтын зорилтот бүлгийг зааж, тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн сургалтын хэрэгцээ, үндэслэлийг тодорхойлсон байх

5.2.3.Сургалт нь удирдах ажилтан, мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлтод заасан чиг үүрэг, үндсэн зорилт, гол үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, чадварт үндэслэсэн агуулга, нэртэй байх

5.2.4. Сургалтын агуулга нь зорилтот бүлгийнхээ мэргэжил, арга зүйн хөгжлийн хэрэгцээ, тухайн төрлийн сургалтын зорилгод нийцсэн байхын зэрэгцээ багшид сонголт хийх, сонирхсон асуудлаа гүнзгийрүүлэн судлах боломж олгосон байх

5.2.5. Сургалтын арга зүй нь оролцогчдын мэдлэг чадвар, туршлага, хандлагыг хүндэтгэсэн, тэдгээрт тулгуурласан байх

5.2.6.Сургалтын хөтөлбөрт танхимын сургалтаас гадна танилцах аялал, дадлага туршилтын үйл ажиллагааг тусгасан байх

5.2.7.Сургалт явуулах байршил, хугацаа, сургалтын зардлын бүтэц, хэмжээ, нийт өртөг, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон байх

5.2.8.Зайны сургалтын дэвшилтэт арга, технологи, электрон хэрэглэгдэхүүн, тэдгээрийг хэрэгжүүлэх орчин нөхцөлд тавигдах шаардлага нь тодорхой байх

5.2.9.Сургалтад хэрэглэгдэх болон бие даан судлах ном, сургалтын хэрэглэгдэхүүний жагсаалт, хаягтодорхой байх

5.2.10.Суралцагчийн сургалтаар эзэмшсэн мэдлэг, чадвар ба сургалтын үр дүнг бодитоор үнэлэх үйл ажиллагааны график, арга, хэлбэр тодорхой байх,

5.2.11.Сургалт явуулах багийн гишүүдийг танилцуулсан байх

Зургаа. Давтан сургах сургалтын санхүүжилт

6.1.Сургалтыг зохион байгуулах санхүүжилтийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дах заалтыг үндэслэн /...төрөөс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгах арга хэмжээ авах.../ жил бүр нийгмийн хамгааллын салбарын төсөвт суулгах арга хэмжээг авах

6.2. Сургалтын зардал дараах эх үүсвэрээс санхүүжнэ. Үүнд:

6.2.1.Нийгмийн хамгааллын салбарт ажиллаж байгаа удирдах ажилтан мэргэжилтнүүдийн статистик судалгаа, тухайн сургалтын нэг суралцагчид ногдох зардлыг үндэслэн тооцсон улсын төсөв

6.2.2.Сургалтын зардлыг яам, агентлаг болон тэдгээрийн аймаг, нийслэлийн салбар, харьяа байгууллагаас тухайн жилд зохион байгуулахаар баталсан сургалтын төлөвлөгөөг үндэслэн төсөвлөсөн улсын төсөв, төсөл, хөтөлбөр, хандив тусламж

6.3. Давтан сургах сургалтын зардлыг дараах байдлаар төсөвлөж, санхүүжүүлнэ.

6.3.1.Сургалтын зардлыг нэг суралцагчид ногдох зардлаар төсөвлөж, санхүүжүүлнэ. Энэ зардал нь сургалтын төлбөр, унаа, томилолтын зардлаас бүрдэнэ.

6.3.2.Сургалтын зардалд хөтөлбөр боловсруулах, сургагч багшийн ажлын хөлс, сургалтын хэрэглэгдэхүүн, бичиг хэргийн зардал, сургалтад хамрагдсаныг гэрчлэх батламж хэвлэх зардал тус тус багтана.

6.3.3.Сургалтын хөтөлбөр боловсруулах, гарын авлага зохиогчдод олгож буй ажлын хөлсийг тухайн үеийн зах зээлийн дундаж жишгээр тооцно.

6.3.4.Сургалтад оролцогчийн аймгаасаа тухайн бүс ба нийслэлд зорчих, сургалт нь сургууль, аймаг, бүсэд зохион байгуулагдах тохиолдолд сургагч багшийн унаа, томилолтын зардлыг тухайн үед мөрдөж буй баталгаажсан жишиг зардлаар тооцно.

6.3.5.Сургалтыг зохион байгуулж байгаа болон оролцож буй хугацаанд нь оролцогчдод ажиллаж буй байгууллагаас нь цалинтай чөлөө олгоно.

Долоо.Давтан сургах сургалтын үр дүнгийн тайлагналт

7.1. Давтан сургах сургалтын үр дүнг дараах байдлаар тайлагнана. Үүнд:

7.1.1.Сургалт явуулсан байгууллага, Хамтарсан сургалтын баг нь сургалтын тайланг гаргаж, эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулан тухайн оны 11 дүгээр сард багтаан албан тоотоор болон "электрон" хэлбэрээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

----- о О о -----